

Улс хоорондын Роуминг үйлчилгээний үзүүлэлтүүд



Өмнөх үг

Дараах шинэ үзүүлэлтүүдийг 2020 оны есдүгээр сард болсон ОУЦХБ-ын Цахилгаан холбоо/МХХТ-ийн үзүүлэлтүүдийн эксперт группын (EGTI) 11 дэх хуралдаанаар баталсан бөгөөд олон улсын роумингийн үйл ажиллагаа болон ачааллыг хэмжихэд нэмэлт мэдээлэл өгөх зорилготой.

Эдгээр үзүүлэлтүүдийн тодорхойлолт болон аргачлал нь EGTI-ийн Олон улсын роумингийн үзүүлэлтүүдийн дэд бүлгийн тайланд үндэслэгдсэн.

Өгөгдлийг "Дэлхийн Цахилгаан холбоо/ МХХТ-ийн үзүүлэлтүүдийн Урт Асуулга 2021" (*World Telecommunication/ICT Indicators (WTI) Long Questionnaire 2021*) - с цуглуулж эхэлсэн.

ШИНЭ Үзүүлэлт: Улс орон түвшний роумингийн гэрээтэй орнуудын тоо (i133crn)

Тодорхойлолт:

Энэ үзүүлэлт нь үнэ төлбөргүй эсвэл үндэсний (existing) тарифтай харьцуулахад тусгай роумингийн тарифтайгаар гэрээ байгуулж баталгаажуулсан улс орнуудын нийт тоог илэрхийлнэ. (Жишээ нь: EU-ийн "Roaming Like at Home (RLAH)" санаачилга.)

Улс орны түвшний роумингийн гэрээ (CLRAs) гэдэг нь тус улс хоорондын (trans-national) зохицуулалтын шийдвэрээр баталгаажсан роумингийн гэрээ бөгөөд иймээс тухайн орнуудын операторуудын хоорондын бүх арилжааны гэрээнүүдээс давсан хүчин чадалтай болно. CLRAs-ийн ач холбогдол тогтмол өссөөр байна (хавсралт 1-ийг үзнэ үү).

Энэхүү үзүүлэлт нь тус улс нь нэг буюу хэд хэдэн улстай үнэ төлбөргүй эсвэл тусгай тариф бүхий роумингийн гэрээ байгуулсан эсэхийг ITU-д мэдээлэх зорилготой.

Мэдээлэл цуглуулах арга:

Мэдээллийг **улсын зохицуулах байгууллага (NRA)** эсвэл **холбогдох яамнаас** цуглуулж болно.

Арга зүйн асуудлууд:

Хэрэв улс CLRAs-д оролцдоггүй бол хариу нь 0 байх ёстой. Хариултын тайлбар хэсэгт CLRAs-ийн тоо, холбогдох мэдээллийг заавал тэмдэглэнэ.

Хэрэв үзүүлэлтийн хариу 0-ээс их бол, дараагийн роумингийн ачаалалтай холбоотой бүх үзүүлэлтэд CLRAs-ийн мэдээллийг оруулах шаардлагатай.

Харин Зохицуулах байгууллага нь CLRAs-д оролцдоггүй бол дараагийн CLRA үзүүлэлтүүдийг хоосон үлдээх хэрэгтэй.

Хэрэгцээ, ач холбогдол:

Энэ үзүүлэлтийг цуглуулах гол зорилго нь ОУЦХБ-д тухайн улс ямар CLRAs-д оролцож байгааг жил бүр мэдээлэх явдал юм. CLRAs-ийн бодит ач холбогдлыг тухайн роумингийн үзүүлэлтүүдэд CLRA-ийн хувь хэмжээг тооцоолсноор харуулдаг.

ШИНЭ Үзүүлэлт: Хөдөлгөөнт өргөн зурвасын интернет ачаалал (улсын гадна, CLRAs-д роуминг хийх), Экза байтаар (i136mwoa)

Тодорхойлолт:

Хөдөлгөөнт өргөн зурвасын интернет ачаалал (улсын гадна, роуминг хийх) гэдэг нь тухайн улсын өөрийн хэрэглэгчид гадаад улсын сүлжээнд үүсгэсэн өргөн зурвасын ачааллыг заадаг. Энэ нь тухайн улсын улс орны түвшний роумингийн гэрээ (CLRA) байгуулсан орнуудад хамаарна. Орж ирж буй ачаалал нь 3G сүлжээ болон түүнээс илүү дэвшилтэт хөдөлгөөнт сүлжээнээс үүссэн бөгөөд 3G-ийн сайжруулалт, шинэчлэлт, эсвэл ижил утгатай дата дамжуулалтын хурдтай стандартуудыг багтаана. Татах (download) болон илгээх (upload) ачааллыг нийлүүлж, хамтад нь тайлагнана. Ачааллыг эцсийн хэрэглэгчийн холболтын цэг дээр хэмжинэ. Бөөний (wholesale) болон walled-garden ачааллыг оруулахгүй. Ачааллыг экзабайтаар (exabytes) хэмжинэ.

Арга зүйн асуудлууд:

Энэхүү үзүүлэлт нь CLRA-тэй орнуудын жижиглэнгийн роумингийн дата ачааллыг хэмждэг. Тиймээс зөвхөн операторын түвшний гэрээтэй орнуудыг оруулахгүй.

Бусад үзүүлэлтүүдтэй уялдаа холбоо:

Энэ нь i136mwo (улсын гадна, роуминг хийх, Exabytes-д) үзүүлэлтийн нэг дэд үзүүлэлт бөгөөд зөвхөн CLRA-тэй орнуудад үүссэн outbound роумингийн дата ачаалалд хамаарна.

Жишээ:

Грек улсын жижиглэнгийн роумингийн дата ачааллыг жижиглэнгийн дата үйлчилгээний ачаалал (GB)-тай харьцуулсан.

	2015	2016	2017	2018	2019
Хөдөлгөөнт өргөн зурвасын дата ачаалал	36'056'409	47'087'271	97'876'012	147'573'359	271'578'920
Роуминг дата ачаалал (=i136mwo)	31'650	178'585	776'137	2'174'174	4'061'761
CLRA роуминг дата ачаалал (=i136mwoa)			353'142	1'695'856	3'208'791

ШИНЭ Үзүүлэлт: Гадаадад роуминг хийж буй дотоодын хэрэглэгчдийн ярианы хугацаа (улс орны түвшний CLRAs роумингийн гэрээний дагуу), минутаар (i1334wma)

Тодорхойлолт:

Гадаадад роуминг хийж буй дотоодын хэрэглэгчдийн ярианы хугацаа (CLRAs-ийн хүрээнд) гэдэг нь тухайн улсын хэрэглэгчид гадаадын сүлжээнд байх үедээ хийсэн болон хүлээн авсан нийт ярианы минут (outbound roaming) юм.

Өөрөөр хэлбэл, энэ нь тухайн улсын өөрийн сүлжээний хэрэглэгчид, тухайн улс улс орны түвшний роумингийн гэрээ (CLRA) байгуулсан гадаадын сүлжээнд холбогдож байх үед үүсгэсэн жижиглэнгийн олон улсын роумингийн ярианы нийт хугацаа юм.

Энэхүү үзүүлэлтэд дотоодын сүлжээний хэрэглэгч биш, түр хугацаагаар дотоодын сүлжээнд роуминг хийж буй гадаадын хэрэглэгчдийн ярианы минутуудыг оруулахгүй.

Тайлбар ба хамрах хүрээ:

Зарим тохиолдолд операторууд хэрэглэгчдэдээ бодит ярианы хугацаагаар биш, өөр төрлийн тарифийн схемийн дагуу төлбөр тооцдог. Тухайлбал хамгийн бага дуудлагын үргэлжлэх хугацаа, зөвхөн бүтэн минут тутамд тооцох төлбөр, хамгийн бага дуудлагын хураамж, гэх мэт. Ийм нөхцөлд бодит ярианы хугацаа ба төлбөрт (n төлөгдсөн) ярианы хугацаа хоёрын хооронд зөрүү гардаг. Энэ үзүүлэлтийн зорилго нь, хэрэв ийм зөрүү байгаа бол төлбөрийн (billed) ярианы ачааллыг цуглуулахад оршино. Дээр дурдсан ялгааг эс тооцвол, бодит ба төлбөрийн ярианы ачаалалд минутын хэмжилт, цуглуулах арга болон арга зүйн хувьд бусад ялгаа байхгүй. Нэмж хэлэхэд, төлбөрийн (billed) роумингийн ярианы ачаалал нь бодит ачаалалтай тэнцүү эсвэл илүү байх ёстой гэж үздэг.

Бусад үзүүлэлтүүдтэй хамаарал:

Энэхүү үзүүлэлт нь дараах үзүүлэлтийн дэд үзүүлэлт юм: Гадаадад роуминг хийж буй дотоодын хэрэглэгчдийн ярианы хугацаа (outbound roaming), минут (i1334wm). Гэхдээ энэ нь зөвхөн CLRA-тэй орнуудтай холбоотой, жижиглэнгийн түвшинд бодитоор төлөгдсөн (billed) роумингийн ярианы ачаалалд хамаарна.

Жишээ:

Грек улсын жижиглэнгийн роумингийн ярианы ачааллыг тухайн улсын жижиглэнгийн дотоод ярианы үйлчилгээний ачаалалтай (сая минут) харьцуулсан.

	2015	2016	2017	2018	2019
Ярианы ачаалал (бодит минут)	27'211	26'793	27'454	28'063	29'070
Ярианы ачаалал (төлбөрийн минут)	26'196	26'906	27'624	28'627	30'285
Роуминг ярианы ачаалал (бодит минут)	154	166	277	517	588
Роуминг ярианы ачаалал (төлбөрийн минут)	159	172	285	528	600
CLRA роуминг ярианы ачаалал (бодит минут)			126	404	458
CLRA роуминг ярианы ачаалал (төлбөрийн минут)			130	412	468

Хавсралт 1

ЕGТI-ийн дэд бүлгийн тайланд дурдсанаар, улс орон түвшний роумингийн гэрээний ач холбогдлын талаар Олон улсын цахилгаан холбооны байгууллагын (ITU) "Харилцаа холбоо/МХХТ-ийн захиргааны өгөгдөл цуглуулах гарын авлага" (ноорог хувилбар – 2019 оны 9 дүгээр сарын 11, баримт бичиг №3)-д олон удаа дурдсан байдаг. Үүнд:

хуудас 113: "Дэлхийн зарим бүс нутагт зохицуулалтын тодорхой дүрэм хэрэгжиж байгаа бөгөөд энэ нь хэрэглэгчийг гадаадад яриа эсвэл дата үйлчилгээ ашиглах үед (хамгийн багадаа тодорхой хэрэглээний хэмжээнд) нэмэлт төлбөр төлөхөөс чөлөөлдөг. Жишээлбэл, 'Roam Like at Home' буюу үнэгүй роумингийн бүс нутагт хэрэглэгч тухайн улсын дотоод хэрэглээндээ тохиролцсон тарифын дагуу төлбөр төлдөг гэсэн үг юм. Харин энэ "стандарт хэрэглээ"-ний түвшнээс давсан яриа, мессеж эсвэл дата хэрэглээнд нэмэлт буюу ахиу төлбөр (жишээ нь минут тутам эсвэл MB тутамд) ногдуулж болно."

хуудас 114: "Дэлхийн зарим бүс нутагт улс орнууд хоорондоо роумингийн хураамжийг арилгах эсвэл тусгай дүрэм (жишээ нь 'Roam Like at Home') хэрэгжүүлэхээр тохиролцсон. Энэ нь иргэд өөр улс руу аялж, ажиллах үед харилцаа холбооны болон хөдөлгөөнт үйлчилгээний саадыг бууруулах зорилготой."

хуудас 139: "Дэлхийн зарим бүс нутагт 'үнэгүй роумингийн бүс' нэвтрүүлж эхэлсэн бөгөөд үүгээр дамжуулан роумингийн хураамжийг ихээхэн бууруулсан эсвэл бүрмөсөн устгасан. Жишээлбэл, Европын Холбоо 2017 оноос 'Roam Like at Home' зохицуулалтыг хэрэгжүүлсэн."

хуудас 140: "Олон улсын роуминг нь дэлхийн олон бүс нутагт тусгай зохицуулалтын хяналтанд орсон бөгөөд энэ хүрээнд үйлчилгээний төлбөрийг бууруулж, хэрэглэгчдийн үйлчилгээний эрэлт, хэрэглээний хэмжээг мэдэгдэхүйц нэмэгдүүлсэн."

хуудас 141: "Европын Холбоонд яриа болон SMS-ийн жижиглэн (ба бөөний) үнэ дээр хязгаар тогтоосон роумингийн зохицуулалт 2007 оноос мөрдөгдөж эхэлсэн. 2017 онд 'Roam Like at Home' зохицуулалт хүчин төгөлдөр болж, өмнө нь өндөр байсан роумингийн үнийг дотоодын тарифтай ижил түвшинд бууруулсан. Үүний үр дүнд, Европын Холбоонд аялж буй дотоодын хэрэглэгчдийн ярианы хэрэглээ мэдэгдэхүйц өссөн."

хуудас 142: "Дэлхийн олон бүс нутагт янз бүрийн хэлбэрээр 'үнэгүй роумингийн бүс' нэвтрүүлж байна."

хуудас 145: "Дэлхийн олон хэсэгт 'үнэгүй роумингийн бүс' бодитоор хэрэгжиж эхэлсэн бөгөөд үүгээр дамжуулан роумингийн тусгай төлбөрийг бүрэн устгасан эсвэл эрс бууруулсан. Үүнд Европын Холбоо, Персийн булангийн орнууд, Mercosur-ийн орнууд болон Төв Африкийн бүс багтана."

хуудас 146–148: "Дэлхийн олон бүс нутагт улс орнууд харилцан тохиролцож, 'үнэгүй роумингийн бүс' байгуулах талаар гэрээ байгуулж байна. Үүний үр дүнд, роумингийн үйлчилгээний төлбөр дотоодын тарифтай харьцуулахад өндөр байхаа больж, мэдэгдэхүйц буурч байна. Ийм шинэчлэлийг хийхийн тулд тухайн улсын дотоодод буй гадаад хэрэглэгчдийн дата, яриа, мессежийн хэрэглээний хэв маягийг судлах нь чухал юм. Энэ нь үнэгүй роумингийн бүс байгуулах үр нөлөө, үр дагаврыг шинжлэх, эсвэл тийм бүс байгуулагдаагүй тохиолдолд хэрэглээний хувьсал, нэгж үнэ, ачааллын урсгал, сүлжээний хүчин чадлын шаардлагыг үнэлэхэд ашиглагдана."

Одоогийн үзүүлэлтүүдтэй хамаарал:

"Улс орон түвшний роумингийн гэрээтэй орнуудын тоо (i133crm)" үзүүлэлт нь өмнө нь байсан аливаа үзүүлэлттэй шууд холбоогүй.

	Үзүүлэлт	Дэд үзүүлэлт
Роуминг ачаалал: дата	Улсын гаднах хөдөлгөөнт өргөн зурвасын интернет ачаалал – гарах дата роуминг (i136mwo)	Хөдөлгөөнт өргөн зурвасын интернет ачаалал (улсын гадна, CLRAS-ийн хүрээнд гарах), Экза байтаар (i136mwoa)
Роуминг ачаалал: яриа	Гадаадад роуминг хийж буй дотоодын хэрэглэгчдийн ярианы хугацаа (outbount roaming), минутаар (i1334mw)	Гадаадад роуминг хийж буй дотоодын хэрэглэгчдийн ярианы хугацаа (CLRAS-ийн хүрээнд), минутаар (i1334wma)